

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-23

1. “Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай” Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонсох 4-23

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
04 дүгээр сарын 02-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 09 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баделхан, Б.Бат-Эрдэнэ, Н.Наранбаатар;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Ц.Сэргэлэн;

Тасалсан: Б.Дэлгэрсайхан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээр”-ийн төслөө татан авч байгаа тухай мэдэгдэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо./11:16/

Нэг. “Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай” Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав, Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Д.Отгонбаяр, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсүх, Л.Нямтөмөр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого, зохицуулалтын газрын дарга Г.Энхмөнх, мөн яамны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн ахлах шинжээч Ё.Нямжав, Усны газрын дарга З.Батбаяр, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал, мөн газрын Газрын тос, бүтээгдэхүүний газрын дарга Б.Түвшинжаргал, Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга С.Түвшинбаяр, Кадастрын хэлтсийн дарга Д.Батмагнай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

“Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай” Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал, мөн газрын Газрын тос, бүтээгдэхүүний газрын дарга Б.Түвшинжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Б.Энх-Амгалан нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай” Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 12 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 16 минут үргэлжилж, ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
11 цаг 09 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энх-Амгалан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн, Норовын Алтанхуяг чөлөөтэй, Ганибалын Амартүвшин ирсэн, Пүрэв-Очирын Анужин гишүүн ирсэн, Хавдисламын Баделхан гишүүн гадаад томилолттой, Энхтайваны Бат-Амгалан гишүүн чөлөөтэй, Баагаагийн Баттөмөр гишүүн ирсэн, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн орон нутагт томилолттой, Сүхбаатарын Батболд гишүүн өвчтэй байна, Дашидондогийн Ганбат гишүүн ирсэн байна, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн чөлөөтэй байна, Нанзадын Наранбаатар гишүүн орон нутагт томилолттой байна, Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна, Цэдэвийн Сэргэлэн гишүүн өвчтэй байна, Дамдины Цогтбаатар гишүүн ирсэн байна, Нямаагийн Энхболд гишүүн ирсэн байна, Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн ирсэн байна. Ингээд ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. 1.Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол

Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 3 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсоно. 2.Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцэнэ. Ийм 2 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудал батлагдлаа.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Уул, уурхай хүнд үйлдвэрийн яам С.Магнайсүрэн УУХҮЯ-ны ТНБД, Б.Анхбаяр УУХҮЯ-ны Газрын тосны бодлогын газрын газрын дарга, Ч.Хишигдалай УУХҮЯ-ны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга, Л.Баярмандал АМГТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Түвшинжаргал АМГТГ-ын Газрын тос бүтээгдэхүүний газрын дарга, Д.Батмагнай АМГТГ-ын Кадастрын хэлтсийн дарга, С.Түвшинбаяр АМГТГ-ын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга, ХЗДХЯ Б.Солонгоо ХЗДХ-ийн дэд сайд, БОАЖЯ Б.Бат-Эрдэнэ Монгол Улсын ЗГ-ын гишүүн, БОАЖ-ын сайд, З.Батбаяр Усны газрын дарга, Г.Энхмөнх Хүрээлэн буй орчны бодлогын зохицуулалтын газрын дарга, Ё.Нямжав Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн ахлах шинжээч, Сангийн яам Ж.Ганбат Сангийн яамны ТНБД, Тэлмэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Б.Батжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, О.Хоролмаа мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг хариуцсан мэргэжилтэн, Татварын ерөнхий газар Ч.Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга, С.Төгсжаргал Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга, Б.Тэлмүүн

Татварын ерөнхий газрын Татварын бодлогын газрын дарга, Үндэсний аудитын газар Д.Загджав Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ц.Наранчимэг Үндэсний аудитын газрын Аудитын 2 дугаар газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Отгонбаяр, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Л.Нямтөмөр Үндэсний аудитын газрын Санхүү нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Ц.Батсүх Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор эдгээр хүмүүс оролцож байна. БОАЖ-ын, ГХЯ-наас, тийм байна. Ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

Эхлээд энэ Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай асуудлаар Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн хоорондох хэлэлцээрийн төслийн асуудлаар Бат-Эрдэнэ сайд мэдээлэл хийх үү? 4 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга болон Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлаас эргүүлэн татах тухай асуудлыг танилцуулъя.

Даян дэлхийн ногоон хөгжлийн институт нь Рио Де Жанейро хотноо Даян дэлхийн ногоон хөгжлийн институт үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийн дагуу 2012 онд байгуулагдсан бөгөөд 2014 оноос эхлэн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байна. Тус байгууллага нь гишүүн орнууддаа хүлэмжийн ялгарлыг бууруулах, ногоон ажлын байр бий

болгох, хог хаягдлын менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зэрэг чиглэлээр буцалтгүй тусламж, техникийн туслалцааг үзүүлж, төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж ирсэн. Даян дэлхийн ногоон хөгжлийн институт нь одоогоор 71 улсад гишүүнчлэлтэй бөгөөд ЗГ хоорондын гэрээгээр хэрэгждэг ОУБ-ын жишигт нийцүүлэн тус байгууллагын эрх зүйн болон ОУБ-ын статусын зохицуулалт хийх ЗГ-ын хэлэлцээрийг батлуулах шаардлага үүссэн.

Үүний дагуу тус байгууллагын эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын ЗГ болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээрийн төслийг ЗГ-ын 2021 оны 18 дугаар тэмдэглэлээр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралд хэлэлцүүлж, дэмжсэн тохиолдолд уг хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг ажлын шугамаар гаргахаар тогтсон. Гэсэн хэдий ч хэлэлцээрийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүссэн тул хэлэлцээрийн төслийг эргүүлэн татах саналтай байна. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Бат-Эрдэнэ сайдад баярлалаа. Хэлэлцээрийн төслөө эргэж татаж аваад нэмэлт, өөрчлөлт оруулаад буцаж оруулж ирэх юм байна гэж ойлголоо зөв үү? 4 номерын микрофоныг өгөөдөхье.

Б.Бат-Эрдэнэ: Зөв.

Б.Энх-Амгалан: Ойлголоо. Тэгвэл хэлэлцээрийн төслийг ЗГ-т буцаалаа.

11.16 цаг

Нэг. “Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай” Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонсох

2 дахь асуудалдаа оръё. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 3 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсоно. Мэдээллийг хэн хийх вэ? Уул, уурхай хүнд үйлдвэрийн сайд, Засгийн газрын гишүүн, Их Хурлын гишүүн Ганбаатар сайд орж ирсэн байна. Мэдээллийг УУХҮЯ-ны ТНБД Магнайсүрэн танилцуулъя. 5 номерын микрофоныг өгье. 5 уу, 6 юу? 6 номерын микрофоныг өгье. Магнайсүрэн дарга түр хүлээж байгаарай. Байнгын хорооны 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоолоор Газрын тосны салбарын хөрөнгө оруулалт, экспорт, эрэл хайгуул, ашиглалт, олборлолт, байгалийн нөхөн сэргээлтийн асуудлаар газар дээр нь ажиллаж, мэдээлэл авах, тулгамдаж буй асуудлыг судлан шийдвэрлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх зорилгоор Дорнод аймгийн Тамсаг булгийн сав газарт ажиллах санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөр ахлуулсан байгуулсан. Ажлын хэсгийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр танилцуулна. Баттөмөр гишүүний микрофоныг өгье.

Б.Баттөмөр: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2021 оны 3 дугаар тогтоолоор Газрын тосны салбарын хөрөнгө оруулалт, экспорт, эрэл хайгуул, ашиглалт, олборлолт, байгалийн нөхөн сэргээлтийн асуудлаар газар дээр нь ажиллаж, мэдээлэл авах, тулгамдсан буй асуудлыг судалж шийдвэрлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх зорилгоор Дорнод аймгийн Тамсаг булгийн сав газарт ажиллах санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллалаа.

Ажлын хэсэг 2021 оны 12 дугаар сараас хойш Дорнод аймгийн нутаг

дэвсгэрт орших Тамсаг булгийн сав болон Тосон-Уул 19, Тамсаг 21 дүгээр талбайн үйл ажиллагаа явуулж байгаа Петро Чайна Дачин Тамсаг компанийн үйл ажиллагааны талаар УУХҮЯ-наас 63, БОАЖЯ-наас 19, Үндэсний аудитын газраас 13, Татварын ерөнхий газраас 20, МХЕГ-аас 65, ГЕГ-аас 3 нийт 164 хуудас материалыг хүлээн авч, нэгтгэн ажлын хэсгийн гишүүдийг мэдээллээр хангаж, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд тайлан мэдээллийг сонсгосон.

Улмаар Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 3 дугаар тогтоолыг батлан ЗГ-т чиглэл өгсөн. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 78 дугаар захирамжаар газрын тосны ашиглалтын Тосон-Уул 19, Тамсаг 21 дүгээр талбайнуудад байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авсан Петрочайна Дачин Тамсаг компанийн хэрэгжүүлж буй бүтээгдэхүүн хуваах гэрээг дүгнэх, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг мөн ажлын хэсгийг мэдээллээр хангах зорилгоор Шадар сайдын 2013 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 51 дүгээр тушаалаар ХЗДХ-ийн дэд сайд Солонгоор ахлуулсан ажлын хэсгийг байгуулсан байна. Ажлын дэд ажлын хэсэг нь, ахлуулсан дэд ажлын хэсгийг байгуулсан байна.

Дэд ажлын хэсэг нь Петрочайна Дачин Тамсаг компанийн үйл ажиллагааг газар дээр нь танилцаж, бүтээгдэхүүн хуваах гэрээ болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж, санал танилцуулгыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2021 оны 3 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэгт ирүүлсэн. Түүнчлэн ЗГХЭГ-аас газрын тосны бүтээгдэхүүн хуваах

гэрээнээс Монгол Улсын хүртэх ашгийг нэмэгдүүлэх тухай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 22 оны 3 дугаар тогтоолын хэрэгжилтийг 24 оны 1 дүгээр сарын 11-ний байдлаар 11-ний өдрийн ХГ/87 тоот, Хэрэг эрхлэх газрын 87 дугаартай албан бичгээр ирүүлээд байна. Иймд энэхүү тогтоолын хэрэгжилтийг өнөөдөр сонссоноор ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болж байна. Цаашид холбогдох Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналтаа тавиад явах нь зүйтэй гэсэн саналыг гаргаж байна.

Энэ ингэж энэ санал болбол юу вэ гэхээр энэ ажлын хэсэг байгуулагдаж байгаа Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хэлэлцэх үед болбол энэ Үйлдвэржилтийн байнгын хороо байгаагүй байсан. Тэгээд одоо бол Үйлдвэржилтийн байнгын хороо болбол ажиллаж байгаа учраас энийг холбогдох байгууллагын Байнгын хороод нь хэлэлцээд явах нь зүйтэй гэсэн ийм саналыг гаргаж байгаа юм. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Баттөмөр гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн ахлагч мэдээлэл хийлээ. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 3 дугаар тогтоолоор Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх талаар ЗГ-т чиглэл өгөх тухай тогтоолын төслийг баталсан. Уг тогтоолын хэрэгжилтийн талаарх танилцуулгыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ТНБД Сандагийн Магнайсүрэн танилцуулна. 6 номерын микрофоныг өгье.

С.Магнайсүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын хэмжээнд 93-аас 2023 оны хооронд 14 аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан газрын тосны хайгуулын 32 талбай ялгаснаас өнөөдрийн байдлаар 9 талбайд газрын тосны хайгуулын, 6

талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын, 4 талбайд газрын тосны ашиглалт олборлолтын үйл ажиллагааг бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явагдаж байна. Гэрээлэгч ААН-үүд 93 оноос 2023 оны хооронд газрын тосны хайгуул судалгааны ажилд нийтдээ 375 сая ам.доллар зарцуулаад байгаа бөгөөд хайгуулын ажлын үр дүнд Тосон-Уул, Тамсаг, Зүүнбаян, Цагаан элс, Цэн тогоруу гэх газрын газрын тосны 4 ордыг нээсэн.

Хайгуулын 2 талбайд буюу Галба 11, Хөх нуур 18 талбайнуудад газрын тос илэрч Галба 11 талбайд газрын тосны нөөцийн үнэлгээг хийж байна. Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос 2022 оны 5 сарын 24-ний өдөр, өдрийн 03 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр болон газрын тосны салбарын хөрөнгө оруулалт, экспорт, эрэл хайгуул, ашиглалт, олборлолт, байгалийн нөөц, нөхөн сэргээлтийн талаар холбогдох 12 чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллахыг даалгасан ийм тогтоол гаргасан. Энэ өгсөн чиглэлүүдийн дагуу чиглэл бүрээр товч танилцуулга хийе. Нэмэлт тайлбар тодруулгыг манай ажлын хэсгийн гишүүд холбогдох хүмүүс ирсэн байгаа учраас тодруулж хариулах бололцоотой байгаа.

Улсын Их Хурлын, 1 дүгээрт газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг Монгол Улсын эрх ашигт нийцүүлж, хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллах талаар. Монгол Улсын Их Хурлын 2014 онд баталсан Газрын тосны тухай хууль болон ЗГ-ын 15 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварт нийцүүлж 16-аас 19 онд хийгдсэн 13 хайгуулын гэрээг шинэчилсэн. Ашиглалтын үе шатын 3 талбайн гэрээ шинэчлэх ажил гэрээлэгч талаас зарчмын зөрүүтэй санал гарсны улмаас шинэчлэгдээгүй байгаа. Мөн 4 талбайг ЗГ-ын тогтоолоор цуцалсан.

Нэг талбайн асуудал шүүхийн маргаантай байсны улмаас шинэчлэгдээгүй ингээд үлдсэн ийм дүнтэй байна. 2024 оны 1 дүгээр сарын байдлаар газрын тосны хайгуулын 9, газрын тосны ашиглалтын 4 талбайн гэрээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнээс газрын тосны ашиглалтын Тосон-Уул 19, Тамсаг 21 талбайнуудад байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авсан Хятадын төрийн өмчит Петрочайна Дачин Тамсаг компани болон Бүтээгдэхүүн хуваах гэрээт 97 талбайд ажиллаж байгаа Хятадын төрийн өмчит Доншен газрын тос компанитай бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх ажлыг 16-аас 18 онд холбогдох яамд, байгууллагуудын агентлагийн түвшинд 4 удаа ажлын хэсэг байгуулагдаж ажиллаж өнөөдрийг хүрсэн. Гэвч талууд нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй. Гэрээлэгч талаас тухай бүр бүтээгдэхүүн хуваах гэрээнийхээ үндсэн зарчмыг хэвээр хадгалах байр суурийг илэрхийлж ирснээс болоод асуудлыг шийдвэрлэх асуудал удааширч өнөөдрийг хүрсэн үндсэн шалтгаан болж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд 2022 оны 78 дугаар захирамжаар уг Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг шинэчлэх асуудлыг дүгнэх, хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх ажлуудыг судалж боловсруулах ажлын хэсгийг Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан байгуулсан. Мөн энэ ажлын хэсэгт мэдээллээр хангах, туслах ийм ажлын дэд хэсгийг Хууль зүйн дэд сайдаар ахлуулж байгуулсан. Ингээд дэд хэсгийн гишүүд болоод бусад холбогдох чиглэлээр гишүүд саналаа боловсруулж, ажлын хэсэгт бол хүргүүлсэн байгаа. Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсэг 22 оны 12 дугаар сард Петрочайна Дачин тамсаг компанийн хөрөнгө оруулагч болох Петрочайна Дачин Ойлфилл Лимитед компанийн гэрээ шинэчлэх талаар яриа хэлэлцээр хийхээр урьсан. Манай талаас болбол хэлэлцээрийг эхлүүлэх талаар болбол холбогдох санал

санаачилгыг гаргаж бол ажилласан байгаа.

Ажлын хэсгийн явцыг 23 оны 5 сарын 29-ний өдөр ЗГ-ын хуралдаанд танилцуулсан. Үүнтэй холбогдуулаад Ерөнхий сайд 96 дугаар захирамжаа гаргаж, Бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх ажлыг ЗГХЭГ-ын даргаар ахлуулж байгуулахаар тогтсон байгаа. Ажлын хэсгийн даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу гишүүд хариуцсан чиглэлийнхээ дагуу мэдээллийг бэлтгэж нэгтгэсэн. Түүнчлэн ажлын хэсгийн ахлагч болон зарим гишүүд 23 оны 11 сард БНХАУ-д айлчилж, Хятадын Үндэсний газрын тосны корпорацын ТУЗ-ийн дарга болон холбогдох албаны хүмүүстэй уулзаж, гэрээг шинэчлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах талаар уулзалт ярилцлага хийж, санал солилцсоны үндсэн дээр Хятадын талаас хамтран ажиллах ажлын хэсэг томилуулан ажиллуулахаар тохиролцсон. Энэ ажлын хэсгийг Хятадын Үндэсний газрын тосны корпорацын дэд захирал ахлан ажиллахаар болсон байгаа. Ингэснээр ажил эрчимжих нэг алхам болсон гэж бид үзэж байгаа.

2 дугаарт газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг хийснээс хойших хугацаанд Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт, үр ашиг, өгөөжийг тооцох, Петрочайна Дачин тамсаг компанийн үйл ажиллагаанд экспертийн дүгнэлт гаргах үүрэг бүхий холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан багийг томилж ажиллуулах энэ ийм чиглэл өгөгдсөн. ХЗДХ-ийн дэд сайдаар ахлуулсан ажлын дэд хэсэг ажлын том ажлын хэсэгт бол тусалж, зөвлөн тусалж ингэж бол ажилласан. Ажлын дэд хэсэг 22 онд 4 удаа хуралдсан бөгөөд нийтдээ цөөнгүй хугацаагаар ажлын зарим гишүүдийн хамтаар Дорнод аймгийн удирдлагуудтай хамтарч, тухайн компанийн хэрэгжүүлж байгаа Тосон-Уул болоод Тамсаг талбайд ашиглалт явуулж

байгаа үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж ажилласан. Энэ саналын хүрээнд тус талбайд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтэд болон гэрээлэгчийн батлуулсан газрын тосны нөөцийн тайланд талуудын үр ашгийг нэмэгдүүлэх, газрын тосны ашиглалтын үйл ажиллагаанд ашиглаж буй техник технологийн нөхцөл байдалд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжээч байгууллагаас зөвлөх үйлчилгээ авч дүгнэлт зөвлөмж гаргуулах нь зүйтэй гэж үзсэн байгаа, үзсэн. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжээч байгууллагаас зөвлөх үйлчилгээ авах асуудлаар ажлын хэсэг одоогоор хэлэлцэж бол шийдвэрлээгүй байна.

3 дугаарт Ашигт малтмалын тухай болон Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Их Хурлын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцүүлэх тухай ийм чиглэл байсан. Монгол Улсын Их Хурлын хууль тогтоомжийг боловсронгуй болгох Улсын Их Хурлын тогтоол болоод Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалт батлах тогтоолд тус асуудлууд бол төлөвлөгдөж тусгагдсан. Өнөөдрийн байдлаар Уул уурхай хүнд үйлдвэрийн яаман дээр Ашигт малтмалын тухай хуулийг бид боловсруулаад холбогдох яамдаас саналаа аваад бэлэн болгосон. 2 яамны тухай зарчмын зөрүүтэй санал байгаа. Энэ нь болбол Сангийн яам болоод ХЗДХЯ-тай хол холбоотой 2 санал зарчмын зөрүүтэй байгаа. Энэ зарчмын зөрүүтэй саналыг бид ойрын хугацаанд гаргаад ЗГ-ын хуралдаанд оруулахаар төлөвлөсөн. Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад Ашигт малтмалын тухай хуулийн төсөл туссан байгаа. Бусад газрын тостой холбоотой хуулиудын тухайд Ашигт малтмалын тухай хуулийн төсөлтэйгөө уялдуулан бид холбогдох үр дагаварт үнэлгээ хийх

судалгаануудыг хийгээд, төслийг боловсруулаад төрийн захиргааны төв байгууллагуудаасаа санал авах түвшинд бол ирээд ажиллаж байгаа гэдгийг бол хэлье.

4 дүгээрт Дорноговь аймгийн Алтаниширээ сумын нутаг дэвсгэрт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдийн тогтвортой нөөцөөр хангах бэлтгэл ажлыг зохион байгуулах. Газрын тосны хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлэх, шинээр нөөцийг тогтоох, ашиглах үйл ажиллагааг дэмжих гэсэн ийм чиглэл өгөгдсөн. Петрочайна дачин тамсаг компанийн үйл ажиллагаа болон газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай газрын тосны нөөцийн талаар ЗГ-ын хэд хэдэн удаагийн хуралдаанд танилцуулсан. УУХУ-ийн сайдын 22 оны холбогдох тушаалуудаар Бүтээгдэхүүн хуваах гэрээг ЗГ-ын тогтоолоор цуцалсан болоод гэрээний хугацаа дуусгавар болсон гэрээлэгчгүй байсан зэрэг нийт 15 талбайд газрын тосны хайгуулын нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласан. Үүний үр дүнд 4 талбайд ААН-үүдээс санал ирж, Газрын тосны тухай хууль болон гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу гүйцэтгэгчийг тодруулсан. 1 талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээ ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлэн болсон. 2 талбайд гэрээний төсөлд холбогдох яамнуудаас санал авах шатандаа процесс явж байна. 1 талбайн гэрээний төслийг хуульд нийцүүлэхээр ажлын хэсэг гаргаад ингээд ажиллаж байгаа гэсэн ийм дүн мэдээг танилцуулж байна.

5 дугаарт Петрочайна Дачин Тамсаг компанийн байгаль орчны менежментийн 20 оны төлөвлөгөөний биелэлтийг хангуулах 21, 22 оны төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд яаралтай баталж хэрэгжилтэд хяналт тавих гэсэн ийм чиглэл өгөгдсөн. 22 оны 6 дугаар сард БОАЖЯ-наас ахалсан

ажлын хэсэг Дорнод аймгийн Засаг даргаар байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа талбай дээр ажиллаж, байгаль орчны менежментийн 20 оны төлөвлөгөөний биелэлтийг 21 оны хэрэгжүүлсэн байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн асуудалтай хамтруулан биелэлтийг хэрэгжүүлэх талаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. Ингээд 22 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 7 сарын 8-ны өдөр бол баталсан, батлуулсан байна.

6 дугаарт НДШ-тэй холбоотой үүссэн маргааныг хууль тогтоомжийн дагуу эцэслэн шийдвэрлэх, шаардлагатай бол холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Петрочайна Дачин Тамсаг компанитай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг хууль тогтоомжид нийцүүлэн олон улсын гэрээний түвшинд хүргэж шинэчлэх эсвэл татварыг давхар ноогдуулахгүй, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын ЗГ БНХАУ-ын ЗГ хоорондын 91 оны хэлэлцээрт өөрчлөлт оруулах замаар үүссэн асуудлыг шийдвэрлэх талаар санал дэвшүүлсэн. Ажлын хэсгийн түвшинд гэрээг шинэчлэх талаар 2 талын уулзалт хэлэлцээрийг эхлүүлэх үед уг асуудлыг хэлэлцэх асуудлын нэг хэсэг болгон авч үзэж, шийдвэрлэх ийм байр суурьтай хүлээгдэж байгаа.

7 дугаарт Петрочайна Дачин Тамсаг компанид 2018 онд нэмэгдсэн өртгийн албан татвар болон ААНОАТ, ХХОАТ-ыг төлөх тухай тавьсан шаардлагатай холбоотой гомдлыг Татварын ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх гэсэн ийм чиглэл байсан. Татварын ерөнхий газар уг компанитай Бүтээгдэхүүн хуваах гэрээний зүйл заалт, холбогдох тооцоолол, мэдээллийг хамтран шалгаж, нэгдсэн санал, дүгнэлтэд хүрэх шаардлагатай гэж үзсэн I дүгээрт.

Түүнчлэн 22 оны 7 сарын 8-ны өдөр Маргаан таслах зөвлөлөөс энэхүү татварын маргааныг дахин хэлэлцээд татварын байцаагчийн тавьсан шийтгэлийн хуудсыг түдгэлзүүлж, дахин шалгуулахаар татварын дээд шатны байгууллагад буцаахаар шийдсэн. Мөн татварын ерөнхий, мөн Татварын маргаан таслах зөвлөл 23 оны 1 сарын 13-ны өдөр өмнөх татварын улсын байцаагчийн 18 оны шийтгэлийн хуудсыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн ийм байдалтай байгаа. 2011 онд болбол мөн яг ийм кэйс ийм тохиолдлоор болбол татварын байцаагчийн тавьсан шийдвэр шийдвэрийг болбол хүчингүй болгож шийдэж байсан ийм тохиолдол бас бий. Өнөөдөр Татварын маргаан таслах зөвлөлийн шийдсэн шийдлийг яг процессын хувьд хэлэх юм болбол ийм байгаа юм.

8 дугаарт газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанд үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа гүний ус ашиглах технологийг өөрчилж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай орчин үеийн дэвшилтэт техник технологийг үе шаттай нэвтрүүлэх. Петрочайна Дачин Тамсаг компанийн үйл ажиллагаанд хөндлөнгийн олон улсад нэр хүнд бүхий хараат бус эксперт томилон ажиллуулах тохиолдолд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаанд шаардагдах гүний ус ашиглах технологийг өөрчилж, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл багатай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ажиллах талаар зөвлөмж боловсруулан мөрдүүлэх боломж бүрдэнэ гэж ажлын дэд хэсэг дээр үзсэн.

9 дүгээрт газрын тосны хайгуул, олборлолтын үеийн үйл ажиллагаанаас үлдсэн чанарын шаардлага хангахгүй устгах шаардлагатай химийн бодисын хог хаягдлыг олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргийн дагуу шийдвэрлэх. 20-оос 21 онд аюултай хог хаягдлыг хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах талаар журам

хэрэгжиж эхлээгүй байсан. Мөн энэ талаар үйл ажиллагаа явуулах ААН байгаагүйгээс тус талбай дээр хуримтлагдсан химийн бодисоос шалтгаалан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт хангалтгүй гэж дүгнэгдэж ирсэн. Тэгвэл 22 оны 9 сараас аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх бүхий тодорхой компани Тосон-Уул 19 талбайд хуримтлагдсан химийн бодисыг устгах ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус компани мөн хугацаанаас хойш тухайн талбайн хэмжээнд 592,8 тонн химийн бодисыг Налайх дүүрэгт байрлах өөрийн үйлдвэр лүүгээ тээвэрлэж, устгал хийж зохих журмын дагуу ажилласан ийм дүн мэдээтэй байна.

10 дугаарт газрын тосны экспортын тээвэрлэлтийг шороон замаар хийж байгаагийн улмаас тухайн орон нутаг бэлчээр ихээр сүйдэж, тоосжилт үүсэж байгаа тул хатуу хучилттай авто замын барилгыг барилгын ажлыг яаралтай дуусгах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ авах. Бүтээгдэхүүн хуваах гэрээт 21 дүгээр талбайгаас Баянхошуу хилийн боомт чиглэлийн 58,5км хатуу хучилттай авто замыг хийж ажлыг 2023 оны 8 дугаар сард бүрэн дуусгаж, холбогдох замын тэмдэг тэмдэглэгээг хийсэн. Одоо улсын комисст хүлээлгэн өгөхөөр өгөхөд бэлэн болсон ийм байдалтай байна.

11 дүгээрт Петроцайна Дачин Тамсаг компанийн зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн орон нутгийн тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох байгууллагатай хамтран ажиллах. Энэ хүрээнд АМГТГ, Дорнод аймгийн Матад, Халх гол сумын Засаг дарга нар болон Петроцайна Дачин Тамсаг компани хооронд байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх,

нийгмийн хариуцлагын гэрээг 22 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр байгуулсан. Энэ гэрээнд хэд хэдэн гол зүйлийг тусгаж хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа. Үүний нэг нь Халх гол сумын нутаг дэвсгэрт сумын иргэдийн оршин суугаа орон сууцын барилгуудын сантехникийн шугам хоолойг шинэчлэх ажлын хүрээнд ажил эхэлсэн бөгөөд суурийн ажил бүрэн хийгдэж дууссан, одоо холболт угсралтын ажил бол үргэлжилж байна. Мөн Ялалт багийн хүн эмнэлгийн болон багийн Засаг даргын ажлын байрны барилгын ажлыг дуусгасан, одоо дотор засал хийгдээд дуусаж, дуусах шатдаа байгаа. Мөн Ялалт багийн сургуулийн гадна дулаалгын засварын ажлыг хийж дууссан. Матад сумын иргэдийн хурлаас шийдвэрлэсний дагуу сум байгуулагдсаны ой болохтой холбоотойгоор тус сумын зүгээс наадмын талбай барьж байгуулах ажлыг санал болгосны дагуу барилгын ажлыг гүйцэтгэж байна. Мөн сумын хогийн цэгийн бүтээн байгуулалтын ажил болон төрийн албан хаагчийн орон сууцын барилгын ажил дуусгаж, Матад сумд хүлээлгэн өгсөн байна.

Халх гол болон Матад сумын удирдлагууд Петроцайна Дачин Тамсаг компанитай хамтарсан уулзалтыг 22 оны 9 сарын 21-ний өдөр УУХҮЯ, АМГТГ, Петроцайна Дачин Тамсаг компани, Халх гол сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, төлөөлөгч нар мөн Матад сумын Засаг дарга, иргэдийн хурлын дарга, төлөөлөгчидтэй хамтран зохион байгуулсан, энэ зохион байгуулж, байгаль орчныг хамгаалах орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэрээг Петроцайна Дачин Тамсаг компани Халх гол болон Матад сумын засаг дарга нартай тус тус байгуулсан.

12-т нь Петроцайна Дачин Тамсаг компани болон туслан гүйцэтгэгч компаниудад ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийн тоог нэмэгдүүлэх, сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг холбогдох төрийн байгууллагатай хамтран зохион байгуулах. Петроцайна Дачин Тамсаг

компани Дорнод аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран мэргэжлийн дипломтой ажилтан сонгон шалгаруулж, ажилд авч байгаа бөгөөд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг ШУТИС болон бусад сургалтын байгууллагатай хамтран жилд 1-ээс 2 удаа зохион байгуулж, бүх ажилтнуудыг хамруулж хэвшсэн. Туслан гүйцэтгэгч компанийн тухайд улирлын чанартай ажил гүйцэтгэдэг ба орон нутгаас хөдөлмөр зуучийн компаниар дамжуулан түр ажилд ажилтан авахдаа мэргэжлийн диплом шаарддаггүй. Түр гэрээт Монгол ажилчид цооногийн өрөмдлөг, туршилт үйлчилгээний зэрэг ажлуудад дагалдан ажилтнаар ажилладаг бөгөөд Дачин компанид 2022 оны 10 дугаар сард үндсэн 559 Монгол ажилчид, туслан гүйцэтгэгч ангиудад 250 Монгол ажилчид ажиллаж байсан бол 23 оны төгсгөлийн төгсгөлд үндсэн 612 Монгол ажилчин, туслан гүйцэтгэгч 50 Монгол ажилтан ажиллаж байна. Петрочайна Дачин Тамсаг компанийн үндсэн Монгол ажилчдын тоо нэмэгдсэн бөгөөд тухайн жилийн батлагдсан хөтөлбөр, төсвийн дагуу гүйцэтгэх ажил үүргээс хамааран туслан гүйцэтгэгч ААН-үүдэд ажиллах Монгол ажилчдын тоонд өөрчлөлт бас орж явдаг болохыг, орж явдаг байна.

Ингээд нийтдээ Байнгын хорооноос өгсөн 12 чиглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын талаар товч мэдээлэл хүргэлээ. Нэмж тодруулах асуулт тодруулах зүйлүүдэд манай ажлын хэсгийн гишүүд бэлэн хариулахад бэлэн байна. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Магнайсүрэн даргад баярлалаа. Петрочайна Дачин Тамсаг компанийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд гарч буй сөрөг нөлөөлөл, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар авч байгаа арга хэмжээний талаарх танилцуулгыг ЗГ-ын гишүүн, БОАЖ-ын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ танилцуулна. 4 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Байнгын хорооны 2022 оны 5 сарын 24-ний өдрийн 3 дугаарт Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсад хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай тогтоолын хүрээнд хийгдсэн БОАЖЯ-тай хамаарал бүхий асуудлуудыг та бүхэндээ танилцуулъя.

Тогтоолын 5 дугаарт Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн байгаль орчны менежментийн 2020 оны төлөвлөгөөний биелэлтийг хангуулах 2021, 2022 оны төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд яаралтай баталж, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хариуцуулсан. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2020 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ажлын хэсэг 2022 оны 7 сарын 7-ны өдөр ажилласан боловч дүгнээгүй. 2021 оны биелэлтээр Дорнод аймгийн БОАЖГ-ын ажлын хэсэг ажилласан боловч дүгнүүлж чадаагүй. Улсын Их Хурлын 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн Улсын Их Хурлын 04/5025, 5085 дугаар, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн дугаар 3 хүсэлт дагуу БОАЖ-ын сайдын сайдын 2022 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн удирдамжийн дагуу ТНБД-аар ахлуулсан ажлын хэсэг газар дээр нь ажиллаж, 2022 оны 7 сарын 4-ний, 4-өөс 7-ны өдрүүдэд ажиллаж хугацаатай 9 асуудлаар үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 21 дүгээр талбай Дорнод аймгийн БОАЖГ-ын ажлын хэсэг 90,4 хувьтай, 19 дүгээр талбай 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр 95,1 хувьтай тус тус дүгнэгдсэн байна. Тогтоолын 8 дугаар хүрээнд газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанд

үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа гүний ус ашиглах технологийг өөрчилж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай орчин үеийн дэвшилтэт техник технологийг үе шаттай нэвтрүүлэхийг даалгасан.

Петрочайна Дачин Тамсаг ХХК ус ашигласны төлбөртэй холбогдуулан 2021 онд 1881095392 төгрөг, 2022 онд 1484492096 төгрөг, 2023 оны 3 дугаар сарын байдлаар 286276992 төгрөгийг төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн боловч ус ашиглагчийн үүргээ хэрэгжүүлээгүй, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлгүй ус ашигласан зөрчил илэрсэн. Энэ зөрчилд холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 1.4 дэх хэсгүүдийг үндэслэн зөрчлийн хэрэг үүсгэн 5 мянган нэгжээр торгох шийтгэл оногдуулсан. Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 19 дүгээр талбайд координацын цэг, тодорхой координацын цэг зөвшөөрөлгүй худаг гаргасан, малчны худаг гэх тайлбар гаргасан нь газар дээрх худгийг 205 221 205 246 дугаартай лацнуудаар хааж битүүмжилсэн.

Тогтоолын 9 дүгээрт даалгасан газрын тосны хайгуул, олборлолтын үеийн үйл ажиллагаанаас үлдсэн чанарын шаардлага хангахгүй устгах шаардлагатай химийн бодисын хог хаягдлыг олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргийн дагуу шийдвэрлэх үүргийг өгсөн. Үүн дээр Дорнод аймгийн Матад сум дахь Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 19 дүгээр талбай дээр хугацаа нь дууссан устгах шаардлагатай 32 нэр төрлийн 620,7 тонн устгах шаардлагатай химийн бодис хадгалагдаж байсан. Эдгээр химийн бодисуудыг тус компани 2009 оноос өмнө импортлон оруулж ирсэн бөгөөд буруу хадгалалтаас шалтгаалан ашиглалтын шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй аюултай хог хаягдал болсон байсныг БОАЖЯ-ны ТНБД-аар ахлуулсан ажлын хэсэг 2022 оны 7 дугаар сарын 4-өөс 8-ны өдрүүдэд Дорнод аймагт ажиллан, Петрочайна Дачин Тамсаг

ХХК-д хугацаатай албан даалгавар өгч, тус химийн бодисын аюултай хог хаягдлыг Петрочайна Дачин Тамсаг ХХК Элемент ХХК-тай гэрээ байгуулан, график төлөвлөгөөгөө гарган ажиллаж, 2022 оны 11 дүгээр сараас эхлэн химийн бодисын аюултай хог хаягдлыг төлөвлөгөөний дагуу устгаж эхэлсэн. 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 32 нэр төрлийн хоёр зуун, 620,7 тонн хог хаягдлыг бүрэн устгалд оруулсан.

Тогтоолын 10 дугаар заалт бүхий газрын тосны экспортын тээвэрлэлтийг шороон замаар хийж байгаагийн улмаас тухайн орон нутгийн байгаль орчин, бэлчээр ихээр сүйдэж, тоосжилт үүсэж байгаа тул хатуу хучилттай авто замын барилгын ажлыг яаралтай дуусгах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авах үүрэг даалгаврыг өгсөн. Үүний хүрээнд газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулдаг Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Дорнод аймгийн Тосон-Уул нэрт 19 дүгээр талбайгаас Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигт Зүүн хатавч боомтоор тээвэрлэлтийг 2020 оноос хойш хийхийг хориглосон. 2020 оноос хойш Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн өөрийн хөрөнгөөр барьсан Баянхошуу чиглэлд хатуу хучилттай 200км авто замаар тээвэрлэж байна.

Мөн Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 21 дүгээр талбайгаас төв зам хүртэлх өмнөд Буйрын чиглэлийн 58,5км замыг Петро Чайна Дачин Тамсаг ХХК-ийн хөрөнгөөр байгуулан 6 дугаар сард багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Цаашид тус компанийн газрын тосны экспортын бүтээгдэхүүн 100 хувь хатуу хучилттай замаар тээвэрлэгдэж, байгаль орчинд сөрөг нөлөөллийг бүрэн бууруулах арга хэмжээг авч ажиллалаа.

Нэмэлт мэдээлэл өгөхөд хяналт шалгалттай холбоо бүхий асуудлаар үүссэн ажлын хэсэг байгуулах орон нутагт томилолтоор ажиллуулах тухай

БОАЖ-ын сайдын 2022 оны 7 дугаар сарын 1-ний А/211 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг байгуулагдаж ажилласан. Петрочайна Дачин Тамсаг ХХК эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй химийн бодис ашигласан байх нөхцөл байдал тогтоогдсон. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй, аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлдэггүй, аюултай хог хаягдлын хуримтлал үүссэн нөхцөл байдлыг тогтоосон. 1.2.дээрх нөхцөл байдалд үндэслэн талбай дээр тус бүр Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн нийт мянган нэгжээр торгох шийтгэлийг ноогдуулсан. 1.3.Петрочайна Дачин Тамсаг компани олон жил хуримтлагдсан ашиглалтын хугацаа дууссан химийн бодис, сав баглаа боодол, аюултай хог хаягдлыг устгах, тээвэрлүүлэх талаар Элемент ХХК-тай гэрээ байгуулан 2022 оны 9 сарын 23-наас 22 оны 10 сарын 23-ны өдрийг хүртэлх богино хугацаанд 20 удаагийн ачилтаар 577 тонн химийн бодис, сав баглаа боодлын хаягдлыг шилжүүлсэн бөгөөд Элемент ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж, 2022 оны 11 дүгээр сараас эхлэн Элемент ХХК химийн бодис, аюултай хог хаягдлын график төлөвлөгөөг гарган устгах ажлуудыг эхлүүлсэн бөгөөд 22 оны, 23 оны 12 дугаар сарын байдлаар нийтдээ 32 төрлийн 620,7 тонн хог хаягдлыг устгалд оруулсан гэдэг бүрэн мэдээллийг болбол БОАЖЯ-нд ирүүлсэн. 1.4.Петрочайна Дачин Тамсаг компани 12 нэр төрлийн химийн бодисыг тусгай зөвшөөрөлгүй ашигласан байж болзошгүй, газрын тосоор бохирдсон 4000м³ орчим шороог байгаль орчинд ил задгай хаясан гэх асуудлыг шалгуулахаар Экологийн цагдаагийн албанд 2022 оны 7 сарын 18-ны өдрийн 0601/1540 дугаартай албан бичгээр шилжүүлж, тус газраас эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.

Мөн БОАЖЯ-наас улсын ерөнхий байцаагчийн 5 заалтаар шаардлага хүргүүлсэн. Үүнээс БОАЖЯ хяналт

тавьж ажиллаж байгаа. 1 дүгээр шаардлага болбол ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн технологийг сайжруулах, цэвэрлэсэн бохир усыг хүрээлэн буй орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага MNS49432015 стандартад нийцүүлэх, биелэлтийн хувьд байгаль орчны асуудал дээр Тосон-Уул 19, Тамсаг 21 дүгээр талбайн үйлдвэрийн баазын болон ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн техникийн төслийн зураг Эрчимт өрнөл ХХК-иар гүйцэтгүүлж, 2024 онд ахуйн бохир цэвэршүүлэх байгууламжийг шинэчлэх ажлыг бүрэн гүйцэтгэж дуусахаар төлөвлөн ажиллаж эхлээд байна. Цэвэршүүлэх байгууламжийн холбогдох төсвийг суулгуулж, 2024 ондоо бүрэн багтаан дуусгахаар хяналтын доор ажиллаж байгаа.

2 дугаар шаардлагын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулахыг, агуулах ерөнхий шаардлага MNS64582014 он стандартад нийцсэн химийн бодис хадгалах нэгдсэн агуулах барьж, химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалтын үеийн аюулгүй байдлыг хангах, биелэлтийн хувьд ТА2 буюу Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 19 дүгээр талбайн нэгдсэн байгууламжийн химийн бодисын агуулахыг нэгдсэн байгууламжийн хойд, баруун хойд талд хашиаг сунгаж өргөтгөж 10 метр өргөн, 21 метр урттай, 4,5 метрийн өндөртэй, 2 талаасаа ордог агуулахыг 2023 оны 9 дүгээр сард бүрэн барьж ашиглалтад оруулсан. Тус агуулахад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх шаардлагатай мэдээллийг нэмэлтээр хүргүүлсэн байна.

Шаардлага 3. ЗГ-ын 2023 оны 50 дугаар, 58 дугаар тогтоолоор 2 дугаар хавсралтаар Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийн 2.3.9 дэх заалтын дагуу туслан гүйцэтгэгч болон оператор компаниудад ашиглах химийн бодисыг

ашиглалтын тусгай зөвшөөрлийн жагсаалтад оруулах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийхийг үүрэг болгосон. Биелэлтийн хувьд БОАЖЯ-ны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хурлаар Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 21 дүгээр талбайн тосны олборлох төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд шүүмж хийж, гишүүдийн 100 хувийн шийдвэрээр тодорхой асуудлыг засварлан дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэж буцаасан. Мөн хурлаар хэлэлцүүлсэн үнэлгээний тайланд туслан гүйцэтгэгч компаниудад ашиглах химийн бодисуудыг тусгай зөвшөөрлийн жагсаалтад оруулаагүй.

Шаардлага 4. Үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлыг ангилан ялгах, туслан гүйцэтгэх компаниудын ахуйн болон шингэн аюултай хаягдлыг зориулалтын хогийн цэгт шилжүүлэх, зориулалтын бус газарт үүссэн хог хаягдлыг цэвэрлэхийг даалгасан. Биелэлтийн хувьд Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон-Уул, Бичигтийн боомт хүртэлх сайжруулсан шороон хучилттай авто замын дагуу нөхөн сэргээсэн хуучин карьерт үүссэн их хэмжээний хаягдлыг 2023 оны 11 дүгээр сард компани, Матад сум хамтран 10 хүний бүрэлдэхүүнтэй 2 өдрийн турш цэвэрлэж, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 19 дүгээр талбайд хэлтсийн менежер, ажилтан, Матад сумын Эрдэнэбадрах, Түмэн, Хаан багийн Засаг дарга нар болон байгаль хамгаалагч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг цэвэрлэсэн. Тухайн, мөн дотоодын болон олон улсын тээвэрлэлт хийдэг туслан гүйцэтгэгч ААН-үүдийн ойролцоо үүссэн хур хогийг бүрэн цэвэрлэж дуусгасан. Туслан гүйцэтгэгч компаниудын ахуйн болон шингэн аюултай хог хаягдлыг зориулалтын цэгт шилжүүлээгүй асуудал дээр дахин мэдэгдэл хүргүүлсэн.

Шаардлага 5. 19 дүгээр талбайд газрын тосоор бохирдсон хөрсийг түр

хадгалах цэгийн анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, бохирдсон шороо, хаягдал тос агуулах материалуудыг аюултай хог хаягдлын ангиллын дагуу коджуулж, харуул хамгаалалтыг сайжруулан газрын хөрсөнд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс урьдчилан сэргийлэх, цаашид бохирдсон шороо, талбайг бүрэн нөхөж сэргээх, зохих байгууллагаар саармагжуулах устгалын арга хэмжээг шат дараа авч зохион байгуулахыг үүрэг болгосон. Биелэлтийн хувьд Тосон-Уул 19 дүгээр талбайд хуримтлагдсан тосоор бохирдсон шороог цэвэршүүлэхээр 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу уг ажлын гүйцэтгэгчийг шалгаруулахаар 2023 оны 6 сард тендер зарласан бөгөөд гүйцэтгэгчээр Эко ургамал ХХК шалгарч, улмаар үйлдвэрийн тоног төхөөрөмжөө суурилуулан 2023 оны 8 сарын 12-ноос 2023 оны 10 сарын 14-ийг хүртэл нийт 56 хоног ажиллан, 3350м³ шороог цэвэршүүлээд байна. Тус компани эвдэрсэн хашааг бүрэн засварлаж, хорих, хориглох тэмдэг, тэмдэглэгээг бүрэн байршуулаад байна.

Нэмэлт мэдээлэл хүргүүлэхэд 1, 2, 4 дүгээр шаардлагад эрх бүхий албан тушаалтны зөрчлийн үр дагавраа арилгуулах тухай албадан албан даалгаврыг хугацаанд барагдуулаагүйтэй холбогдуулан Захиргааны хэргийн анхан шатын шүүхэд хүсэлт гаргаж, Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатын шүүхийн шүүгчийн 2023 оны 7 сарын 19-ний өдрийн дугаар бүхий шүүгчийн захирамжаар эрх бүхий албан тушаалтны даалгаврыг албадан гүйцэтгүүлэх тухай шүүгчийн захирамж гарч, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатын шүүхийн 2023 оны 7 сарын 19-ний өдрийн дугаар бүхий гүйцэтгэх хуудсыг гарган хэрэгжилтийг хангуулан ажиллаад байна.

5 дугаар шаардлагад БОАЖЯ-ны 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн А/244 дугаартай тушаалаар томилогдсон ажлын хэсэг Дорнод аймгийн Халх гол, Матад сумын нутаг

дэвсгэрт байрлах Петрочайна Дачин Тамсаг ХХК-д хяналт шалгалтыг хийж, газрын тосоор бохирдсон 4000м³ орчим шороо, хаягдал тос, тос агуулсан бусад материалыг зориулалтын бус газар ил задгай газар хадгалж хаясны улмаас газар, газрын хэвлийд сөрөг нөлөөлөл үзүүлэх нөхцөл байдал үүсэн нь гэмт хэргийн шинжтэй үзүүлэлт үндэслэлээр Экологийн цагдаагийн албанд эрүүгийн хэргийг үүсгэн шалгуулж эхлээд байна.

3 дугаар шаардлагад химийн хорт болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрлийн жагсаалтад ороогүй 9 нэр төрлийн химийн бодисыг тусгай зөвшөөрөлгүй ашигласан, зориулалтын бус агуулахад хадгалсан зөрчлийг 2 агуулах хоёр зуун хоёр, таван зуу, хоёр зуун тавин ес, хорин найм/1271 дугаартай лацаар лацдан битүүмжилж, дугаар бүхий гомдол мэдээллээр бүртгэж, прокурорын нэгдсэн санд бүртгүүлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу удирдлага болгон Эрүүгийн тухай хуулийн 24 дүгээр, 24.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжтэй гэсэн үндэслэлээр Нийслэлийн прокурорын газарт танилцуулж, УЕП-ын 2023 оны 4 сарын 24-ний өдрийн 4/3602 дугаартай албан бичгээр эрүүгийн хэргийн дугаар бүхий Экологийн цагдаагийн албанд шилжүүлэн ажиллаад байна. Мэдээлж дууслаа. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Бат-Эрдэнэ сайдад баярлалаа. Танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Баттөмөр гишүүнээр тасаллаа. Баттөмөр гишүүний микрофоныг өгье.

Б.Баттөмөр: Энэ Байнгын хорооны тогтоолыг 22 оны 5 сард гаргаж байсан. Би тэр үед Байнгын хорооны даргаар ажиллаж байсан, тэгээд 2 жилийн дараа шахуу энэний биелэлтийг сонсож байгаа юм байна. Биелэлт бол хангалтгүй байна нөхдөө. Ямар нэгэн юмны биелэлт ярихаар зэрэг

л нэг баахан төлөвлөгөө яриад л, нэг баахан л бичиг цаас яриад байдаг. Яг бодитой юм ер нь алга байна шүү дээ. Энэ газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг л нэмэгдүүл гэсэн л ийм л юм л энэ тогтоолд туссан шүү дээ. Юу нэмэгдчихэв? Энэ Түвшинжаргал дарга хариуцсан дарга нь сууж байна. Сүүлийн үед энэ газрын тосны үйл ажиллагаа бол бараг зогсонги байдалд орчихсон. Гарч байгаа газрын тосны хэмжээ нь болбол багасаад байгаа. Манай хүртэх ашиг чинь болбол 24 орчим хувь гэж байгаа шүү дээ тийм ээ. Тэгээд нийт хэмжээ нь гараад багасаад байхаар зэрэг тэгээд манай хүртэх ашиг бас л тэгээд л тэр хэмжээгээр багасаад байдаг ийм л юм л даа.

Тэгээд энэ Петрочайна очсон түүх чинь бол Соко гэдэг компаниас дамжиж л очсон шүү дээ. 92 онд чинь бид чинь 90 онд, 92 онд ардчилсан нийгэм байгуулах гээд л жагсааж байх хооронд л нэг баахан гаднынхан орж ирээд л Монголын баялгийг л авсан байдаг. Нэг нь энэ Оюу толгой баахан дамжиж, дамжиж яваад л Рио Тинтод очсон байдаг. 2 дахь нь Соко гэдэг компани аваад л, тэгээд эхнийх нь тэр Оюу толгойг чинь Meta гэдэг компани аваад л ВНР-д очоод л Фрийдландаар дамжаад л тэгээд л энэ Рио тинтод очсон. Энэ газрын тосных нь болохоор зэрэг Соко-гоор дамжаад л энэ Хятадын Петрочайна гэдэг компанид очсон. Ийм л байгаа юм л даа. Тэгээд аль, аль нь Монгол Улсад үр ашиг муутай ийм л гэрээнүүд болчихоод яваад байдаг. Аливаа зүйлд хэлбэрээс гадна агуулга гэж юм байх ёстой. Тэгээд агуулга байхгүй, ийм л байгаад байгаа юм л даа. Тэгээд энэ гэрээнээс хүртэх үр ашгийг яаж нэмэгдүүлсэн юм бэ? Эхний асуулт. Түвшинжаргал дарга сая миний асуусан асуулт нь энэ ер нь яагаад ийм энэ газрын тосны энэ үйл ажиллагаа Петрочайна энэ Дорнодын сав газарт яагаад ийм муу яваад байна вэ, юунд байна вэ? Манайхаас шалтгаалаад байна уу гэсэн ийм 2 дахь асуулт.

Дараа нь болбол энд заачихсан тэр нэг хаягдал бодисууд байдаг. Тэр чинь олон улсын конвенцтой. Тэр үйлдвэрлэгч улс нь энийгээ татаж авч, өөрснөө тэр булшилж барьдаг, устгадаг барьдаг тэр юмнууд нь байдаг юм. Энийг бас энэ тогтоолын тэр 8-д билүү, 9-д нь ч билүү зааж өгсөн байгаа. Энэний хэрэгжилт ямар байгаа вэ?

Хамгийн сүүлчийн асуулт бол юу гэхээр энэ газрын тос олборлоход бол ус ашиглаж байна гэж байгаа. Бидэнд ирж байгаа мэдээллээр тэгж л байсан л даа, одоо яаж байгааг мэдэхгүй. Ус шахаад тэгээд нөгөө тос уснаас хөнгөн учраас дээр нь гарахаар тэрийг авдаг гэж. Энэ технологи бол 90 онд энэ үйлдвэрлэлээс хасагдсан гэсэн ийм зүйлийг бидэнд ярьж байсан. Тэгээд энэ технологи өөрчлөгдсөн үү гэсэн ийм асуултуудад хариулт авъя.

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ? 7 номерын микрофон өгье, өөрийгөө танилцуулаад, тэгээд хариулаад яваарай. Маши тодорхой юмнууд асуусан шүү.

Б.Түвшинжаргал: АМГТГ-ын Газрын тос, бүтээгдэхүүний газрын дарга Түвшинжаргал. Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Ер нь мэдээж энэ гэрээг 1991 оны Газрын тосны тухай хуулийг үндэслээд 93, 95 онд анх Соко компани байгуулсан. 2005 онд Петрочайна компани руу шилжүүлсэн байгаа. Үүнээс хойш үйл ажиллагаагаа Петрочайна компани дагнан хариуцаад ажиллаж байгаа. Ер нь анх гэрээ байгуулахад тухайн үеийн хуулийн дагуу тэр гэрээн дээр ялангуяа бүтээгдэхүүн хуваах гэрээний 10 дугаар зүйл, заалт бол тэр чигээрээ татварын зохицуулалттай байгаа. Туслан гүйцэтгэгч нарын бүх татварыг болбол чөлөөлсөн, татвар авахгүй гэсэн ийм зохицуулалттай явж байгаа. Ер нь яах вэ 12 онд анх нөөц оруулаад, орд ашиглах төлөвлөгөөгөө 12 онд батлуулаад, тэгээд үүнээс хойш 22 онд бид нар

дахиад орд ашиглах төлөвлөгөөгөө шинэчилж батал, нөөцийн тодотголоо хий гэсэн шаардлагын дагуу ингээд манайд төслөө ирүүлчихсэн байж байгаа. 12 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу бол жилдээ 1,5 сая тонн түүхий тос олборлоно гэсэн ийм орд ашиглах төлөвлөгөө батлуулсан.

Үүн дээр үндэслээд манай газрын тосны үйлдвэр ТЭЗҮ-гээ хийгээд жилдээ 1,5 сая тонн түүхий тос үйлдвэрлэж, тос шатахуун, нефтийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гэсэн ийм үйлдвэр ашиглалтад орох гээд ингээд бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа. Үүнээс хойш 15 онд хамгийн их олборлолт буюу жилдээ 1,1 сая тонныг олборлосон 15 онд. Үүнээс хойш бол байнга буурсан байгаа. Сүүлийн жилүүдэд яг энэ бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотойгоор энэ олборлолтын хэмжээ бол тогтмол буурч байгаа. Энэ дээр 4, 5, 4 үндсэн гол шалтгаан байж байгаа. 1 дүгээрт нь бол энэ манай ЗГ бол, ЗГ, төрийн байгууллагуудаас бүтээгдэхүүн хуваах гэрээнийхээ нэмэлт, өөрчлөлтийг хийе, хий гэдэг ийм шаардлагуудыг бол тавьж байгаа. Тухайлбал Татварын ерөнхий газраас ингээд актаа тавьж байгаа. Өнөөдрийн байдлаар 436 тэрбум төгрөгийн акт тавигдчихсан байж байгаа. НДЕГ-аас тавигдсан акт байж байгаа 4,7 тэрбум. Энийг хүчээр биелүүлсэн. Үндэсний Аудитын газраас 66,5 тэрбум төгрөгийн акт тавигдсан байж байгаа. Мөн Дорнод аймгийн аудитын газраас бас актууд тавигдчихсан гээд ингээд өнөөдрийн байдлаар бол нэлээн хэмжээний актууд тавигдчихсан байж байгаа.

2 дугаарт нь энэ олборлолт багасаж байгаа 2 дугаар шалтгаан нь юу вэ гэхээр тэр амнатын асуудал байж байгаа. Бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр бол Монгол Улсын Засгийн, амнат нь бол Монгол Улсын ЗГ-т хуваах бүтээгдэхүүнд орчихсон гээд байж байгаа 8.1 дээр. Гэтэл болбол сүүлийн үед бол мэдээж 14 оны Газрын тосны

тухай хуулийнхаа дагуу амнатыг ноогдуул гэдэг ийм шаардлагыг тавьж байгаа юм. Тэрийг тэрнээс болж Петрочайна компанийн удирдлагууд бол бас энийг зөвшөөрөхгүй байгаа.

3 дугаар асуудал бол мэдээж энэ орон нутгийн болон энэ ТББ-ын эсэргүүцэл маш их байж байгаа тийм ээ, үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй байж байгаа. Тухайлбал нэг жишээ хэлэхэд 22 оны 7 сард газрын тосны үнэ 100 доллароос дээшээ байсан тийм ээ. Тэгэхэд өдөртөө 2 мянган тонн түүхий тос олборлоод экспортчихсон. Тэгэхэд манай өдөрт нэг өдөрт манай Монгол Улсын бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 1 тэрбум төгрөгийг бид нар авдаг байсан. Тэгэхэд орон нутгийн төрийн бус байгууллагууд 9 хоног зам хаахад л бид нар манай ЗГ 9,9 тэрбум төгрөгөө тухайлбал алдаж байх жишээтэй. Гэх мэтчилэн ингээд тэр нөгөө төрийн бус байгууллагуудын эсэргүүцэл маш их байдаг гээд. Эдгээр шалтгаануудаас болоод Петрочайна компанийн олборлолт жилээс жилд багасаж байгаа. Тухайлбал энэ 23 онд 630 мянган тонн тос олборлох төлөвлөгөөтэй байсан. Үүнээс нөгөө хөрөнгө оруулалт нь гээд 200 гаруй сая долларыг бид нар бол төлөвлөгөө төсвийг нь баталж өгсөн. 23 оны жилийн эцсийн байдлаар 48 сая долларын гүйцэтгэлтэйгээр гарсан ¼-ээр. Тэгэхээр.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Нэмээд хариулчихъя, 7 номерын микрофон нэмж өгье.

Б.Түвшинжаргал: Технологийн гол ажлууд хийгдэхгүй байгаа учраас энэ жил 583 мянган тонн тос олборлосон. Яг энэ байдлаараа цаашаа явах юм бол ингээд 27 онд газрын тосны үйлдвэр ашиглалтад ороход 300 орчим мянга, жилдээ 300 мянган тонн олборлох ийм дүр зураг харагдаж байгаа юм. Тийм учраас энэ бүтээгдэхүүн хуваах гэрээний асуудлыг нэг тийш нь болгож, энэ хөрөнгө оруулагч СМРС компанитай

эцсийн байдлаар энийгээ тохирох ийм шаардлагатай байгаа гэж.

Б.Энх-Амгалан: Хариулт хангалттай юу? Бусад асуудалд усны асуудал дээр хэн хариулах вэ? 3 номерын микрофоныг өгье. Батбаяр дарга хариулъя.

3.Батбаяр: Өдрийн мэнд хүргэе. Усны газрын дарга Батбаяр. Яг одоогийн байдлаар 21, 19 дүгээр 2 талбай дээр 21 дүгээр талбай дээр 41 ашиглалтын 41 цооногтой, мониторингийн 17 цооногтой, 19 дүгээр талбай дээр 41 ашиглалтын цооногтой, 8 мониторингийн цооногтой байна. Эрхэм гишүүний асуусан технологийн тухай асуудал дээр бол өөрчлөлт гараагүй байгаа гэсэн ийм ойлголт авсан. Өөрөөр хэлбэл усаа шахаад тэгээд юугаа яг технологийн хувьд бол өөрчлөлт гараагүй. Ус ашиглалтын тухайд бол сая Түвшинжаргал даргын хэлсэн юутай холбоотойгоор бүтээгдэхүүний хэмжээ буурч байгаа, юу гэдэг юм олборлолт буурч байгаатай холбоотойгоор усны хэмжээ бол байнга багасаад байгаа. Хамгийн сүүлийн 23 оны дүнгээр бол 2,6 сая м³ ус ашигласан гэсэн ийм тооцоотой сууж байна.

Зүгээр нэг жижигхэн боловч бас нэг асуудал байгаа. Энийг татварынхаа байгууллагатайгаа ярьж байгаад бид нар бас шийдэх ёстой асуудал байгаа. Тэр нь юу вэ гэхээр энэ компаниас Усны газраар дүгнэлт гаргуулахдаа яг тогтмол 2,7 сая ч гэдэг юм уу тоогоор гаргуулаад байдаг. Яг гүйцэтгэлээрээ болохоор жишээлбэл 2,7м³ усыг ашиглана гэххэд гүйцэтгэл нь болохоор 8 сая болоод ингээд, 800 мянга болоод ингээд 3, 4 дахин тогтоосон хэмжээнээс 3, 4 дахин бага ашиглачихсан учраас тэр ашигласан төлбөрөө багаараа төлнө гэдэг. Өөрөөр хэлбэл тоолуурынхаа дүнгээр төлнө гэдэг. Бидний хувьд бол бас нэгэнт төлөвлөгөө гаргасан бол тэр хэмжээгээрээ ашиглах шаардлагатай гэсэн ийм байдалтай нэг жижигхэн зөрүү байгаа. Энийг бол бид нар

зохицуулах хэрэгтэй байх. Ус ашиглалтын тухайд бол жил болгон улам багасаад байгаа гэдэг зүйл байгаа. Устай холбоотой бас нэг дахиад нэг ярих ёстой асуудал бол хаягдлын далантай холбоотой аюулгүй байдлын тухайн асуудал дээр байнга хяналт тавьж ажиллаж байгаа. Тэгэхээр эрхэм гишүүний асуултад бол технологийн хувьд бол ямар нэгэн өөрчлөлт ороогүй байгаа.

Б.Энх-Амгалан: 4 номерын микрофон нэмж хариулъя. Бат-Эрдэнэ сайдын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баттөмөр гишүүний асуултад нэмж хариулъя. Энэ олон улсын конвенцтой холбоо олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргийн дагуу холбоо бүхий асуудлыг түрүүн танилцуулсан. Ер нь болбол энэ аюултай хог хаягдлыг хадгалах зориулалтын нэгдсэн байр савтай болох холбоо бүхий асуудал энд хөндөгдсөн. Энэ дээр болбол БОАЖЯ тодорхой шаардлагуудыг тавьж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нь батлахгүй байх, тодорхой бас ашиглалттай холбоо бүхий асуудлууд дээр зөвшөөрлийг олгохгүй байх ийм арга хэмжээнүүдийг бол авсан байдаг. Үүний дагуу болбол нэгдсэн агуулах болбол албан ёсоор баригдсан, ашиглагдаж эхэлсэн. Техник технологитой холбоотой асуудлууд болбол цаг хугацааны тодорхой хамаарал бүхий асуудал учраас БОАЖЯ-нд болбол техник технологийн шинэчлэлийг хийж байгаа. Энэ дээр тодорхой хугацаа өгөөч гэдэг ийм албан хүсэлт бол ирсэн.

2022 оны менежментийн төлөвлөгөөг тодорхой тавьсан шаардлагуудыг биелүүлээгүй гэдэг үндэслэлээр БОАЖЯ батлаагүй байсан. Энэ болбол 2022 оны 5 сар хүртэл бараг үргэлжилсэн. Гэхдээ энэ дээр болбол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос менежментийн төлөвлөгөөг батал гэдэг ийм бичиг болбол ирсэн. Үүний дагуу бол ЗГХЭГ

тухайн үед бол Нямдорж сайд ажиллаж байсан. Тэгээд үүний дагуу болбол БОАЖЯ дахиж хяналт шалгалтын ажлын хэсэг явуулаад, тодорхой хэмжээний албан бичиг тоотыг авсны үндсэн дээр менежментийн төлөвлөгөөг баталж, тухайн ажлуудыг үргэлжлүүлж явуулсан байгаа.

Б.Энх-Амгалан: Нэмж асуух уу? Баттөмөр гишүүний микрофоныг өгье, нэмж тодруулъя. 1 минут.

Б.Баттөмөр: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны энэ тогтоолын биелэлт болбол тэг биелэлттэй байна гэж би үзэж байна. Энэ ингээд явсаар явсаар байгаад 300 мянган тонн тостой болоод л нөгөө газрын тосны үйлдвэр ашиглалтад орох үед хэрэгцээнийх нь 5 хувийг л хангах юм байна. Ийм л дүр зурагтай л байж байгаа юм байна шүү дээ. Энэ ийм хөрөнгө оруулалт цаашидаа Монгол Улсад хэрэгтэй юм уу, үгүй юу? Энэ Оюу толгой байна.

Би энд нэг асуулт асууя гэж бодож байна. Эд нарын нэг мөнхийн асуудал бол юу гэхээр энэ татварын маргаан байдаг юм. Оюу толгой төсөл 1,3 их наяд төгрөгийн татварын маргаантай явж байгаа. Энэ Петрочайна Дачин Тамсаг дээр татварын ямар хэмжээний байна вэ, бас л мөнхийн урд нь бас л зөндөө л юм болж байсан. Одоо ямар яг хамгийн сүүлчийн байдлаар ямархуу хэмжээний татварын маргаан явж байна вэ? Ямар шатад явж байна вэ? Нөгөө маргаан таслахаараа орж байгаа юу?

Б.Энх-Амгалан: Татвартай холбоотой асуудлыг хэн хариулах вэ? Тийшээ 2 номерын микрофон дээр сууцих. Татварын Ерөнхий газрын дарга хариулах гэж байна уу, тийм ээ? Маши тодорхой асуулт асуусан шүү. 3 номерын микрофоныг өгье, хариулъя.

Ч.Чимидсүрэн: Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Петрочайна Дачин Тамсаг компанид нийт 4 удаагийн татварын хяналт шалгалт хийгдсэн байгаа. Түүнээс түүрүүний хэлсэн 11 онд бол 350,73 тэрбумын актыг болбол Татварын маргаан таслах зөвлөлөөр бол хүчингүй болгочихсон. Түүнээс хойш 2013-аас 2017 онд хамрах татварын хяналт шалгалт хийгээд 312 тэрбумын татварын акт бол тогтоогдсон байгаа. Түүнээс хойш 2018 онд 87 тэрбумын актыг тавьсан. 2019 онд 46,2 тэрбум буюу ингээд 450 орчим тэрбумын актыг бол тавьсан. 1 удаа хэрэгжүүлэхийг болбол шаардаж байгаа. Татвар.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Гүйцээгээд хариулъя. 3 номерын микрофоныг нэмж өгье.

Ч.Чимидсүрэн: Татварын өр барагдуулахтай холбоотой үе шаттай ажлууд бол хийгддэг. Нэхэмжлэл үүсгэх, шаардах, тэгээд дансыг нь хаах, цаашид эд хөрөнгийг нь битүүмжлэх гэх мэтчилэн. Тэгээд үүн дээр 23 оны 5 сарын 17-нд бас ЗГ-ын шийдвэр гараад бас битүүмжилсэн дансыг болбол нээчихсэн шийдвэр гараад явж байгаа.

Б.Энх-Амгалан: Би 2 юм асуугаадахъя. Ингээд манайхыг, та хэдийн танилцуулга дотор ингээд л 437 тэрбумын акт тавьсан л гэнэ, 312 тэрбумын татварын акт тавьсан л гэнэ, 80 тэрбумын татварын акт тавьсан л гэнэ тэгээд төлдөг юм уу? Яг төлүүлчихсэн юм байна уу та нар? Бас энэ 3,6 их наядын татвар төлөх ёстой л гэнэ. Тэгээд тэр Татварын маргаан таслах зөвлөл чинь эсвэл байцаагчийнхаа шийдвэрийг баталгаажуулчихдаг эсвэл цуцлаад хаячихдаг. Ямар яагаад ийм зөрүүтэй шийдвэр гаргаад байдаг юм бэ? Энэ зөрүүтэй шийдвэрээс чинь болоод наад татварын чинь мөнгө төлөгддөггүй юм биш үү? Энэнийхээ учрыг нэг надад нэг хэлээд өгөөч.

2 дахь нь энэ 12 нэр төрлийн химийн бодис зөвшөөрөлгүй ашигласан л гэнэ, 4000 м³ орчим тосоор бохирдсон

шороог ил задгай хаясан л гэнэ, зөвшөөрөлгүй худаг гаргасан л гэнэ, ус ашигласны төлбөрөө төлдөггүй л гэнэ ингээд хууль хэрэгжүүлдэг юм уу энэ байгууллага чинь, хэрэгжүүлдэггүй юм уу? Тэгээд энэ дээр ямар арга хэмжээ авах гэж байгаа юм бэ цаашидаа ер нь?

3 дахь нь энэ Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу энэ чинь гэрээлэгчийн хувьд газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагаа бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмын дагуу иж бүрэн үнэн зөв тайлагнаагүй. Тийм учраас Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тул Монгол Улсын ЗГ-т гэрээгээ цуцлах зөвлөмж хүргүүлсэн гээд байдаг. Тэгээд гэрээнийхээ үүргийг биелүүлэхгүй байна эд нар чинь гээд байхаар бид нар биелүүлүүлж чадахгүй ингээд суугаад байдаг. Энэ цаашидаа ингэж яваад, тэгээд нөгөө бүтээгдэхүүн хуваах гэрээгээр эд нар яг манай тэр нөгөө Алтаниширээтэд баригдаж байгаа газрын тосны үйлдвэрт бүтээгдэхүүн хуваах уу, түүхий эд өгөх үү? Жил болгон энэ бүтээгдэхүүн нь буураад байгаа юм чинь. Энэ тал дээр нэг хариулт өгөөдхөөч, хэн өгөх вэ? Татварын асуудлаар нь Татварын ерөнхий газрын дарга өгөх үү? Тийм. Дараа нь Бат-Эрдэнэ сайд өгье. Эхлээд 7 номерын микрофон хариулах уу. Баярмандал дарга хариулах уу тийм ээ? 7 номерын микрофон.

Л.Баярмандал: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Ашигт малтмал, газрын тосны газрын үүрэг гүйцэтгэгч Баярмандал байна. Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Даргын асуултад хариулъя. Энэ бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх ажлын хэсэг бол ер нь 2014 онд Газрын тосны хууль гарснаас хойш яригдсан асуудал юм байна лээ. Тэгээд одоогийн байдлаар ЗГХЭГ-ын дарга Амарбаясгалан даргаар ахлуулаад ажиллаж байгаа. 2023 онд Ерөнхий сайдыг БНХАУ-ын улсад хийсэн

айлчлалын үеэр энэ CNPC гээд их компанитай нь уулзалт хийсэн. Түүн дээр бол бас 2 талаасаа бол ингээд ажлын хэсэг гаргая. Тэр Хятадын тэр эх компанийнх нь дэд ерөнхийлөгч нь Хятадын талаасаа, Монголын талаас бол манай ЗГХЭГ-ын дарга ахлаад ингээд явахаар болж байгаа. Эхний ээлжид бол манай дээр дэд хэсэг ажиллаад, ингээд мэдээллээ бэлтгээд явж байгаа.

Ер нь бол 2027 онд газрын тосны үйлдвэр ашиглалтад орно гэж байгаа. Одоогоор үйлдвэр, тэгээд хоолой маань баригдаад явж байгаа. Тийм учраас энэ гэрээгээ бол яаралтай шинэчлэхгүй бол үнэхээр бас газрын тосны үйлдвэрийг хангахад бол одоогийн хүчин чадал бол дутагдаж байгаа. Тэгээд сая бас Түвшинжаргал дарга хэлсэн. Ноднин жил 200 сая долларын бид нар хөрөнгө оруулалтын ажлыг батлахад эх компаниас нь 48 сая долларыг бол баталсан, гүйцэтгэлтэй байгаа. Энэ жилийн хувьд 4 сар гарчихсан. Эх компаниас нь энэ жилийнх нь бас санхүүг нь баталж өгөөгүй байгаа. Тийм учраас манай энэ ажлын хэсгээр хурдан түргэн л ажлаа гүйцэтгээд, Бүтээгдэхүүн хуваах гэрээ хурдан шинэчлэхгүй бол газрын тосны олборлолт маань ингээд багасах бас ийм байдалтай байж байна. Тэгээд энд бас манай төрийн байгууллагуудын хоорондын бас уялдаа холбооны асуудал байгаа. Бид нар ноднин жилээс Аудитын ерөнхий газартай бас нэлээн энэ талаар ярьсан. Тэр акрил суурьтай санхүүгийн тооцооны системийг манай АМГТГ болон Сангийн яаманд нийлээд ингээд сургалт авъя. Бүгдээрээ нэгдсэн ойлголттой болъё гэдэг дээр бол санал нэгдсэн байгаа.

Б.Энх-Амгалан: Нэмээд хэн хариулах вэ? 3 номерын микрофон.

Ч.Чимидсүрэн: Татварын алба болбол Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ийм чиг үүрэгтэй. Ер нь бол татвартай холбоотой улсын төсөвт 209,2 тэрбум, орон нутгийн төсөвт 34 тэрбумыг болбол 98-аас 22 онуудад

болбол төлсөн байна. Түрүүний хэлсэн 4 ч удаагийн хяналт шалгалтын асуудал бий. Тэгэхээр татварын алба бол татвараа ноогдуулаад хойноос нь төлөлт мөн хяналт шалгалтын ажлуудыг бас ийм үе шаттай хийх ийм чиг үүрэгтэй. Тэгээд 2007-гоос 10 онд үүссэн татварын актыг хүлээн зөвшөөрөхгүй Маргаан таслах зөвлөл дээр ороод, тэрэн дээр энэ Бүтээгдэхүүн хуваах гэрээний 10.4-ийг баримтлаад энэ олон улсын гэрээ гэдэг үндэслэлээр болбол татварын актыг бол унагачихсан юм байна лээ.

Түүнээс хойш болбол бид Гадаад хэргийн яамтай хамтарч энэ олон улсын гэрээ мөн үү, үгүй юү гэдэг дээр бол тайлбаруудыг болбол авч ажилласан. Энэ ерөнхий агуулгаараа болбол энэ олон улсын гэрээ биш гэдгээр болбол үзэж, бид нар дараагийн татварын актуудаа болбол тавиад явж байгаа. Энд сүүлд тавигдсан тэр 2013-аас 2017 онд тавигдсан 312 тэрбумын актад болбол Татварын маргаан таслах зөвлөл болбол татварын албаны актыг болбол дэмжээд, энэ бол хүчин төгөлдөр, энийг татварт төлөх ёстой гэсэн ийм шийдвэрийг болбол Маргаан таслах зөвлөл гаргасан байгаа.

Б.Энх-Амгалан: Нөгөө бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбогдуулаад аудитынхан бас хариулт өгөх үү? 3 номерын микрофоныг өгье, 5 номерын микрофоныг өгье. Загджав дарга хариулах уу.

Д.Загджав: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Үндэсний Аудитын газраас Загджав. Энэ Петрочайнатай холбоотой энэ бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохгүй болбол бас их төвөгтэй асуудал байгаа юм. Өнөөдөр өртөг, нөхөгдөх зардал нэмэгдчихсэн байгаа, 7,2 их наяд төгрөг. Сая Баттөмөр гишүүн ярьж байна лээ. Тэр Оюутолгой гээд, энэ мөн Петрочайнагийн өмнө бас нөгөө Англичуудын, Америкчуудын оролцсон

Соко компанийн энэ ажлууд ийм л дүр зурагтай байна. Тэгээд энэ нягтлан бодох бүртгэл дээрээ зарим зүйл нь тогтоогддоггүй, хөтөлдөггүй, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрддөггүй. Манай холбогдох байгууллагуудын тавьсан шаардлагыг биелүүлдэггүй ийм л зүйл яваад байгаа юм.

Зүгээр бид нар энэ 23 оны оны бас төлөвлөгөөг нь дахиад үзэхээр энэ 14-өөс 18 оны хоорондох энэ бид нар бас юу хийгээд дүгнэлт гаргаад ингээд ажиллаж байна. Одоо бас шинээр төлөвлөгөө баталсан. Ингээд бид нар үзээд, дүгнээд ингээд актаа тавиад байдаг. Тэгээд тэр нь бас хэрэгжихгүй ийм юунууд байна. Тухайлбал Оюу толгойн гэрээг ч хүртэл бид нар бас аудит хийж байна. Үзэхэд бол эдний зээлийн хэмжээ мөн л 19,2 орчим тэрбум доллар болчихсон. Ерөнхийдөө бол 51 он хүртэл 2051 он хүртэл бас нэг гэрэл гэгээ муутай иймэрхүү, иймэрхүү юмнууд байгаад байна. Тэгэхээр энэ юмаа бас нэг цогцоор нь шийдэх шаардлага байгаа юм.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Танилцуулгатай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү? Баттөмөр гишүүнээр тасаллаа. Баттөмөр гишүүний микрофоныг өгье.

Б.Баттөмөр: Энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 5 дугаар сарын 3 дугаар тогтоолын хэрэгжилт бол хангалтгүй. Би Байнгын хорооны дарга байхдаа энэ тогтоолыг гаргасан. Өнөөдөр энэ тогтоолын биелэлтийг ингээд та нарын ярьж байгаагаас сонсоход бол ямар ч тийм үр дүн алга. Ийм л байдалтай л байна л даа. Би түрүүн нэг халти хэлээд дууссан. 90 онд бид нар ардчилал гээд л энэ гадаа жагсаж байх үед л баахан гаднын улсууд орж ирээд л энэ нэг хэрэгтэй юмнуудыг нь бүгдийг нь л авчихсан л байдаг. Тэр Оюу толгой гээд сая яригдаж байгаа юм.

Meta oil, Meta copper гэдэг компани Монголын 60 илэрч алт юуны зэсийг авсан, тэрний нэг нь Оюутолгой. ВНР-д худалдсан тэр нөхөр. ВНР нь Фрийдландад худалдсан. Фрийдланд нь Рио Тинтод худалдаад, тэгээд одоо ингээд явна. 2024 оны төсөв хэлэлцэхэд тийм, Оюутолгой төсөл Монгол Улсын төсөвт 900 тийм, 748 тэрбум төгрөг өгнө. Монгол Улсын нэгдсэн төсөв 27 их наяд төгрөг. Монгол Улсын төсвийн 2,7 хувийг энэ дэлхийн 4 дэх том алт, зэсийн үйлдвэр л Монголд өгч байна шүү дээ. Энэ бол ямар ч ашиг алга. Тэгээд 1,3 их наяд төгрөгийн маргаантай зохицъё гэж явдаг гэж тэр Хууль зүйн дэд сайд нь ярилцлага өгчихсөн байсан. Татвар дээр бол зохицно гэдэг асуудал байхгүй шүү дээ.

2 дахь нь энэ Петрочайна Дачин Тамсаг гээд бас бид нарыг жагсааж байх үед л нэг Соко гэдэг компани орж ирээд л энэ манай тэр социализмын үед нөөц нь тогтоогдсон энэ ордуудыг авчихсан байдаг. Тэгээд энэ Соко нь Хятадын Петрочайна Дачин Тамсаг гэдэг компанид худалдчихсан. Тэгээд энэ худалдах маань болбол хэр зэрэг зохицуулалттай явдаг юм, татвар төлдөг юм уу, Монголын төрийн байгууллагуудын ямар хяналттай явдаг юм, юу ч байхгүй л байгаа байхгүй юу. Монголын 2 том төсөл хоёулаа үр ашиг байхгүй, татвар төлөхгүй, Монголын эдийн засагт хувь нэмэр оруулахгүй ийм төсөл бол хэрэг байхгүй шүү дээ. Тэгээд нэг юм ярихаар зэрэг л урдаас л нэг баахан л хар жагсаалт гээд л юм яриад явчихдаг. Монголын ард түмний эрх ашиг, том эрх ашиг гэдэг юм байна нөхдүүд та нар энийг барьж ажиллах ёстой шүү.

Энэ тогтоолын хэрэгжилт бол туйлын хангалтгүй. Сая тэр дарга нарын ярьж байгаа ярианаас жил болгон 600 мянган тонноор төлөвлөөд 500 мянга олсон, ингээд багассаар байгаад нөгөө газрын тосны үйлдвэр 27 онд ашиглалтад орох үед 300 мянган тонн газрын тос олборлох юм байна. Энэний

24 хувь гэхээр нэг юу юм тэр газрын тосны хэрэгцээнийхээ 5 хувийг хангах юм байна, 5 хувь. Үлдэж байгаа 95 хувийг нь хаанаас хангах вэ? Тэр газрын тосны үйлдвэр өөрөө 21 онд ашиглалтад орно гэсэн, одоо 27 он болчихсон явж байгаа. Яаж хангах юм бэ? Ер нь Монголын ажил нэг иймэрхүү л яваад байна даа нөхдүүд минь. Та нар өөрснөө бодно биз. Бүх ажил дээр ийм явж байна шүү дээ. Өнөөдөр яах вэ дээ нэг нүүрсний хэдэн төгрөг орж ирээд төсөв хэдэн төгрөгтэй, тэтгэвэр, тэтгэмжээ нэмээд ингээд нэг гал дараад л явж байгаа. Цаад талд нь энэ ерөөсөө энэ суурь асуудлууд нь ерөөсөө болохгүй байна шүү дээ.

Усны асуудлаа шийдэх ёстой. Мэнэнгийн тал болбол дэлхийд байхгүй хосгүй газар шүү дээ, Мэнэнгийн там болно шүү. Тэр байгаль экологийн алдагдсан байдал. Өнөөдөр зарим газар энэ тосноос чинь нэг литр ус нь илүү үнэтэй байгаа шүү дээ, нэг литр тосноос нэг литр ус нь илүү үнэтэй байгаа. Тэр байгалийн цэнгэг тэр сайхан усыг та нар хамгаалах чиглэлээр бас юм дорвитой юм хийсэнгүй. Тэгээд менежментийн гэрээг нь хийгээд л явчихсан байдаг л юм байна.

Аливаа гэрээ бол 2 талдаа харилцан ашигтай байх ёстой. Энэ гэрээнүүд маань бидэнд ашиг алга. Үр ашиг өгдөггүй, татвар төлдөггүй ийм гэрээ бол Монголд ерөөсөө хэрэг байхгүй цаашдаа. Энийг бол би хатуу хэлье гэж бодоод байна. Ийм гэрээ бол Монголд цаашдаа хэрэг байхгүй. Гэрээ, олон гэрээ ашиггүй гэрээ байгуулснаараа их сайн улс, ардчилсан улс болохгүй шүү дээ. Тийм учраас энэ алдаануудаа засах ёстой. Ямар арга хэмжээнүүд байна, ямар арга хэмжээнүүд авах ёстой энийгээ бүгдийг нь дэс дараатайгаар авч, Монголын ард түмэнд тайлбарлах хэрэгтэй.

Б.Энх-Амгалан: Танилцуулгатай холбогдуулаад гишүүдэд үг хэлж байна. Би нэг зүйлийг бас энд анхааруулж хэлье.

Занданбат дарга тухайн үед Аудитын дарга байхдаа Монгол Улсын Ерөнхий аудитораас хууль Улсын ерөнхий прокурорт гэмт хэргийн шинжтэй мэдээлэл шилжүүлэх тухай материал явсан юм байна, 65 хуудас материал явж. Энэ дотор АМГТГ 2004 онд гэрээлэгчтэй байгуулсан түүхий тос тээвэрлэх, борлуулах протоколоор борлуулалтын зардлыг Монголын талаас эргүүлэн авахаар тохирсон нь Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй нийцэхгүй байна. Уг хэлэлцээр нь хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг болох нь тодорхойгүй байна. АМГТГ нь Газрын тосны тухай хууль болон Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс болоод гэрээлэгч талд эрх зүйн зохицуулалтаар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх ийм давуу байдлыг олгосон байна гэж.

Тэгэхээр уул нь болбол АМГТГ маань жоохон идэвхтэй ажилласан болбол эд нар жоохон хариуцлагатай л байх байж. Энэ болбол Ерөнхий аудиторын дүгнэлт шүү. Та нар маань ийм нэг хүйтэн цэвдэг сэтгэлээр хандсан учраас хүмүүс юмыг чинь төлөхгүй, татвар төлөхгүй, тэр газар усыг чинь бохирдуулаад яваад байх ийм нөхцөл байдлыг үүсгэсэн юм байна шүү. Тийм учраас та нар энэ ажил дээр нэлээн дүгнэлттэй сайн хандаарай гэж хэлэх байна.

Танилцуулгатай холбогдуулаад гишүүд үг хэлж дууслаа. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх талаар ЗГ-т чиглэл өгөх тухай 2022 оны 3 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын байдлын талаар холбогдох яамдын хийсэн танилцуулга, мэдээллийг сонсож дууслаа. Үүгээр уг ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болж байгаа. Цаашид болбол мэргэжлийн Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд бол хяналтаа

*тавиад явна. Мэдээлэл сонсож дууслаа.
Оролцсон гишүүдэд их баярлалаа.*

*Өнөөдрийн хуралдаан өндөрлөлөө.
Ажлын хэсгийнхэнд мөн баярлалаа.*

12.25 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА*

